



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/152


Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Төсөв батлах тухай" 2018 оны 02/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Эрх шилжүүлэх тухай" А/505 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Эрх шилжүүлэх тухай" А/505 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Улаанбаатар хотын нийтийн аж ахуйн тохижилт үйлчилгээний 2019 оны төсвийн Хот тохижилтын бусад зардлаас санхүүжих авто замын эгнээ тусгаарлах хайс, хашлага суурилуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог хавсралт ёсоор байгуулсугай.

2. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зөвлөмжийг нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хүргүүлж ажиллахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  С.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 8-р сарын 30-ны өдрийн  
А.1152 тушаалын хавсралт



### ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	П.Чойжилжав	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Мөнхнасан	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3-р хороо, 24-39 тоотод оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Г.Билгүүн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн